

ЭНХ ТАЙВАНЫГ ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЭГЧ ШИМАДА ХОТЫН УРИА

「Өглөөний мэнд」

「Сайхан амарсан уу Сайхан цэлмэг өдөр байна..」

「Яваад ирье」

「Сайн яваад ирээрэй.」

Өдөр тутмын энэхүү элгэсэг мэндчилгээ нь энх тайван, амар амгаланг илэрхийлж буй бидний үнэт эрдэнэ юм.

Гэхдээ энэ үнэт эрдэнэ маань байгалийн гамшиг, мөргөлдөөн зэрэг олон зовлон бэрхшээлийг даван туулж ирсэн сэтгэлийн тэнхээ, өр нинжин сэтгэлээс буй болж мөн түүгээр хамгаалагдсаар ирсэн юм.

Өнөөгийн бидний хийх гол зүйл бол бүхий л хүний үүрдийн энх тайван, амар амгалантай амьдралын төлөө бие биенээ харилцан хүндлэж, тус дэм болж, ойлголцож, хуваалцдаг нийгмийг буй болгож, улмаар хойч үедээ залгамжилж үлдээх явдал юм.

Бид нар уриалан дуудна.

「 Өнөөдрөөс илүү маргаашийн сайн сайхны төлөө 」

「 Амьдралын үнэ цэнийг түгээхийн төлөө 」

「 Эрхэм таныг бидэнтэй хамт байгаад талархана

Мөн хорвоогийн бүхий л зүйлст 「талархана.」

Бид чангаар зарлана

「Бид хүнийг гомдоож, аз жаргалгүй болгох зүйлийг үл зөвшөөрнө.

「Бид түүхээс өвлөж ирсэн үнэт өвийг үгүй болгохыг үл өршөөнө.」

Бид нар зарлан тунхаглана.

“Оои” голын цэнгэг урсгалаар өсөн торнисон үзэсгэлэнт ногоон байгальтай Шимада хот энх тайваныг дээдлэгч дэлхийн хүмүүсийн хамтаар инээд хөөрөөр бялхсан,гэрэл гэгээтэй ирээдүйн төлөө хүчин зүтгэдэг энх тайвныг эрхэмлэгч хот байхыг зарлан тунхаглана.